



# СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.29 №18 (18)

ҮЙЛ ЯВДАЛ

## ЯАМДЫН ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАР ЦЭРЭГ-СТРАТЕГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТАД ХАМРАГДАВ



Батлан хамгаалах яамнаас яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарын цэрэг-стратегийн бэлтгэл сургалтыг энэ сарын 26-27-ны өдрүүдэд Төв аймгийн Алтанбулаг суманд байрлах Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төв, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид зохион байгууллаа.

Бэлтгэл сургалтын эхэнд БХЯ-ны удирдлагууд Төрийн нарийн бичгийн дарга нарыг хүлээн авч Бүх цэргийн Хар сүлдэд хүндэтгэл үзүүлж, дурсгалын зураг татуулсны дараа Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд очиж, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид ирснээр тус үйл ажиллагаа эхэлсэн юм. Сургалтын

эхний өдөр "Аюулгүй байдлыг хангах үндсэн асуудлууд, нөлөөлөх хүчин зүйлс, Монгол Улсын аюулгүй байдлын гадаад дотоод орчны өөрчлөлт" сэдвээр хурандаа Ц.Отгонбаяр, "Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ" сэдвээр хурандаа С.Ганбямба, "Орчин үеийн дайн, түүний шинж чанар, хэтийн төлөв" сэдвээр хурандаа Г.Эрдэнэбаатар, "Орон нутгийн хамгаалалтын үндэс удирдлага, зохион байгуулалт" сэдвээр доктор, профессор Ц.Дашзэвэг нар тус тус илтгэл хэлэлцүүлгийг өрнүүлэн, тодорхой мэдээллийг өглөө. Сургалтын



дараа ЦДБЭЧ-ын уран бүтээлчид өөрсдийн уран бүтээлийн дээжээс үзүүлж сонирхуулав.

Сургалтын хоёр дахь өдөр "Бус нутгийн цэрэг-улс төрийн орчны өөрчлөлт, Монгол Улсын Зэвсэгт хүчний шинэчлэлт" сэдвээр ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, "Төрлийн цэргийг хөгжүүлэх бодлого, хэрэгцээ, шаардлага" сэдвээр бригадын генерал Ч.Цогтжаргал нар илтгэл тавьсан юм. Үүний дараа Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн зарим бие бүрэлдэхүүн цэргийн үзүүлэх сургууль, зэвсэгтэй ажиллагааны үзүүлэх тоглолт болон байлдааны зэвсэгт техникийн талаар сонирхуулж, холбогдох мэдээллийг

өгч ажиллалаа. Мөн тэднийг буудлагын болон жолоодлогын дадлагын хичээлд хамруулан зэвсэг, техник, галт хэрэгсэлтэй харьцах анхан шатны мэдлэг мэдэгдэхүүнээр хангах ажлыг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн алба хаагчид зохион байгуулсан юм. Сургалтын төгсгөлд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг цаашид хамтран ажиллахад таатай байгаагаа илэрхийлээд, гэрчилгээг дурсгалын зургийн хамт гардуулан өгсөн юм.

Хоёр өдрийн турш зохион байгуулсан уг сургалтад 13 яамны Төрийн нарийн бичгийн дарга хамрагдлаа.

Б.ЭРДЭНЭБАТ

## БАГШИЙН СУДАЛГААНЫ ЧАДАМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗҮЙН СУРГАЛТ ЯВАГДЛАА

Багшийн хөгжлийн төвөөс энэ сарын 24-нд багшийн судалгааны чадамжийг дээшлүүлэх үйл явцад арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш нар судалгааны арга зүйн сайн туршлагаа солилцох, туршлагатай судлаачидтай судалгааны арга зүйн хөгжлийн хандлага, чиглэлийн талаар санал солилцох боломжийг олгох зорилгоор "Их сургуулийн багшийн судалгааны чадамжийг дээшлүүлэх арга зүй" сэдэвт хэлэлцүүлгийг амжилттай зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, доктор (ScD) хурандаа Б.Өлзийхуяг нээж, БХЯ-ны ШУТЗ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (PhD), профессор, хурандаа Д.Содномцог модератороор ажилласан юм.

"Шинжлэх ухааны судалгааны

үндсэн асуудлууд" сэдвээр социологийн ухааны доктор (PhD), профессор Ч.Эрдэнэчулуун, "Их сургуулийн багш судалгааны чадамжаа сайжруулах боломж" сэдвээр БХЭШХ-гийн дэд захирал, доктор (PhD), хурандаа Ж.Мэндээ нар илтгэл тавьж хэлэлцүүлсэн нь цаг үеэ олсон, үр өгөөж, ач холбогдол өндөртэй хэлэлцүүлэг болов.

Хэлэлцүүлэгт ҮБХИС-ийн багш нарын төлөөлөл болох 90 гаруй багш оролцож, шинжлэх ухааны судалгааны үндсэн асуудлууд, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэн санал солилцсон юм.

Төгсгөлд нь багшийн судалгааны чадамжид нөлөөлдөг хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор шууд асуулга, санал хураах ажлыг "mentimeter" програмыг ашиглан явуулж, хэлэлцүүлгийг дүгнэж ажиллалаа.

### ЦАХИМ ШУУДАНД

## НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ БОЛЛО

Зэвсэгт хүчний 325 дугаар анги



Батлан хамгаалах яамны 110 жил, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жил, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хөдөө, орон нутагт сурталчлах, хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн

274 дүгээр тусгай рот Завхан аймгийн Сонгино суманд "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгууллаа.

Өдөрлөгөөр тус тусгай ротын бие бүрэлдэхүүн өөрийн үндсэн үүрэг, зэвсэг техникүүдийг танилцуулж, жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолтыг үзүүлэн, Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс хоолны үзэсгэлэн гаргасан байна. Тус өдөрлөгийг үзэж сонирхсон Сонгино сумын удирдлага, ард иргэд энэхүү өдөрлөгийг зохион байгуулсан Зэвсэгт хүчний 274 дүгээр тусгай ротын удирдлага, хамт олонд баярлаж талархснаа илэрхийлээд, ажлын өндөр амжилт хүслээ.

Мөн Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилсан энэхүү ажил нь хүүхэд багачуудад ирээдүйд цэргийн хүн болох хүсэл сонирхолыг нь төрүүлсэн гэж эцэг эхчүүд нь ярьж байлаа.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 11°C	☁️ -3°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40°C	☁️ 25°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20°C	☁️ 0°C

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,845.0	2,858.0
EUR 🇪🇺	3,332.0	3,397.0
CNY 🇨🇳	433.40	437.70
RUB 🇷🇺	36.66	38.42
JPY 🇯🇵	25.82	26.45
KRW 🇰🇷	2.45	2.58

### КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	321
НИЙТ БҮРТГЭГДСЭН	7014
ЭДГЭРСЭН	4341
НАС БАРСАН	10

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	34
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ	227
ЭДГЭРСЭН	1117
НИЙТ БАТЛАГДСАН	1344

### ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.29  
/ДАВАА ГАРАГ/

**ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН НЭГ ЦАГААН УЛААН ХУЛГАНА ӨДӨР**

Үс засуулвал:  
Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:  
06.37-19.17

Барилдлага: Үл зохилдох

Шүтэн барилдлага: Тийн мэдэхүй

Суудал: Гал

Аргын тооллын 3 сарын 29, Сумъяа гараг. Билгийн тооллын 16, Тугчин одтой, улаан хулгана өдөр. Өдрийн наран 6 цаг 37 минутад мандан, 19 цаг 17 минутад жаргана. Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлгө тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЦЭРГИЙН ШТАБ 100 ЖИЛД

## ОЙН АРГА ХЭМЖЭЭГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭВ

Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн түүхт ойн хүрээнд Увс аймгийн Цэргийн штаб, Монгол Цэргийн нэгдсэн холбоо, тус аймаг дахь салбар холбоо, "Монгол хурандаа" нийгэмлэгийн салбар зөвлөлийн удирдах бүрэлдэхүүнээс 97 настай, ахмад дайчин Д.Рагчаа, 94 настай, ахмад дайчин С.Даваат нарт хүндэтгэл үзүүлэв.

Мөн орон нутгийн "Увс" телевизтэй хамтран

"Цэргийн алба, бидний бахархал" нэвтрүүлгийг хийж олон нийтэд хүргэлээ. Нэвтрүүлэгт Цэргийн штабын ОНХС-ын офицер хошууч Ж.Цэрэнчимэд, Зэвсэгт хүчний 328 тусгай салбарын ахлах ахлагч Б.Ганхөлөг, Хилийн цэргийн 0245 дугаар ангийн МССХ-ийн тасгийн дарга Г.Очирсүрэн, Хилийн 0245 дугаар ангийн ахлах байлдагч Г.Бөхболд нар оролцсон юм.

Түүнчлэн аймгийн ЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн албатай хамтран "Хурандаа" нэвтрүүлгийг хийж, Увс аймаг дахь Хилийн 0245 дугаар ангийн захирагч Д.Амарсанаа, Хилийн 0311 дүгээр ангийн захирагч, хурандаа Д.Ганхуяг, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Б.Баттулга, бэлтгэл хурандаа Ц.Баатар-Эрдэнэ, хурандаа Я.Чулуунбаатар, хурандаа Б.Батчулуун нарыг оролцууллаа. ЕБС-ийн сурагчдын дунд явагдсан "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100" гар зургийн уралдаан, "Эрхмийн дээд Монгол эр хүн" сэдэвт эсээ бичлэгийн цахим уралдааныг зохион тус тус амжилттай зохион байгуулав.

Дээрх арга хэмжээг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах үүднээс орон нутгийн телевиз, сонин, сайтуудаар 20 гаруй удаагийн мэдээллийг өгч ажиллав.

## "МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭВ

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярыг тохиолдуулан ЗХЖШ-ын АУГ-аас зохион байгуулсан "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100" гар зургийн уралдаанд шагналт болон тусгай байранд шалгарсан

сурагчид болон оюутнуудын шагналыг аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаар уламжлуулан гардууллаа.

Мөн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан Монгол цэргийн нэгдсэн холбоо, "Отгонтэнгэр" их сургууль хамтран зохион байгуулсан "Эрхмийн дээд Монгол эр хүн" сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд аймгийн хэмжээнд 30 эсээ ирүүлсэнээс 10-ыг нь сонгон, Монгол цэргийн нэгдсэн холбоонд хүргүүлсэн юм. Нийт 250 гаруй эсээ бичлэгээс Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ЕБС-ийн 12а ангийн сурагч Б.Эрхэм-Эрдэнийн бичсэн эсээ тэргүүлж, шагналаа гардан авлаа.

Аймгийн ЗДТГ-ын Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс эрчүүдээ хүндэтгэл үзүүлэн хөгжөөнт тэмцээн, ая дууны мэндчилгээ, гарын бэлэг гардуулсан бол "Сэлэнгийн долгио" чуулгын дуучин Н.Бат-Орших ая дуугаараа цэргийн баярын мэндчилгээ дэвшүүлээ. Түүнчлэн эрчүүдийн дунд автомат буу задлах тэмцээнийг явуулахад 12 алба хаагч оролцсоноос Хууль, эрх зүйн хэлтсийн архив, сан хөмрөгийн эрхлэгч Н.Дүүрэнбаяр тэргүүлэв.

## ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭ СУРТАЛЧЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Архангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Ойн баярын арга хэмжээний хүрээнд аймгийн удирдлагууд, төрийн цэргийн байгууллагын алба хаагчид Монгол Улсын маршал, өрлөг жанжин Г.Дэмидийн хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлэв.

Мөн "Covid-19" цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан орон нутгийн хэвлэл мэдээллээр мэдээлэл хүргэж, мэндчилгээ, гар зураг, захидлын уралдаан зарлаж, онцлох зочны ярилцлага зэрэг хэд хэдэн телевизийн нэвтрүүлэг бэлтгэв. Үүнээс онцолбол орон нутгийн "Тамир" телевизтэй хамтран "Гэнэтийн бэлэг" нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэв.

Архангай аймгаас 2020 оны 1, 2 дугаар ээлжээр хугацаат Цэргийн албанд татагдаж үлгэр жишээээр алба хааж байгаа Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн байлдагч П.Намдаг, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн байлдагч Б.Мөнгөншагай, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн байлдагч С.Амгалан нарыг онцлон, телевизийн тусгай дугаарт оролцуулсан юм. Тус нэвтрүүлгийг аймгийн телевиз, цахим сүлжээгээр үзэгчдэд хүргэсэн нь иргэдэд Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлан таниулах, цэргийн албаны давуу тал, олон нийтийн дунд зөв хандлагыг түгээн дэлгэрүүлж, хамтран ажилласан явдал боллоо.

Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сумдын ЗДТГ, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулав. Түүнчлэн 1981 онд Архангай аймагт төрсөн зургаан иргэнд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг хүргүүлээ.

Ахмад Ш.ЭРДЭНХҮҮ

ЗАСГИЙН ГАЗАР

## ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Төрийн албаны зөвлөлийн удирдлагуудтай уулзахдаа өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд нийт яамны

Төрийн нарийн бичгийн дарга нартай шуурхай зөвлөгөөнийг Төрийн албаны зөвлөлөөс зохион байгууллаа.

Төрийн байгууллагууд "Алсын хараа 2050" хөтөлбөрийн зорилтод хүрэхэд ямар зам туулах, ямар үүрэгтэй оролцох, ямар үр дүнд хүрэх, ирэх жилүүдэд ямар өөрчлөлт гаргах, шинэчлэлийн үр нөлөөг яаж тооцох зэрэг асуудлаар Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг зөвлөмж өгөв.

Төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэхэд мерит зарчим, шатлан дэвших тогтолцоог бэхжүүлэх, мэдлэг, өндөр үр чадвар, хандлагаараа ялгарах иргэдийг ажиллуулах, сонгон шалгаруулахдаа цогц чадамжаар нь үнэлэх хэрэгтэй гэлээ.

## НЭГ САЯ ТУН "СПУТНИК-V" ВАКЦИНЫГ ИРЭХ САРААС НИЙЛҮҮЛНЭ



Монгол Улсын Засгийн газар болон Улсын онцгой комиссын даргын зүгээс ОХУ-ын талд "Спутник-V" вакциныг ойрын хугацаанд худалдан авах албан хүсэлт хүргүүлсний дагуу нэг сая тун вакцин нийлүүлэхээр болсон тухайгаа ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны сайдын үүрэг гүйцэтгэгч Сергей Анатольевич Цыб энэ сарын 27-нд Шадар сайд С.Амарсайхантай цахимаар "уулзах" үеэр мэдэгдлээ.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ОХУ-ын Засгийн газрын дарга М.В.Мишустинд, Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан Оросын шууд хөрөнгө оруулалтын сангийн Ерөнхий

захирал К.А.Дмитриев нарт тус тус захидал илгээсний дагуу вакцин нийлүүлэх гэрээг байгуулжээ. ОХУ-аас худалдан авах гэрээний хүрээнд нэг сая тун вакцин нийлүүлэхээс гадна хүмүүнлэгийн тусламжаар 300 мянган тун "Спутник-V" вакциныг нэмж нийлүүлэхээр ажиллаж байгаа талаараа ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны сайдын үүрэг гүйцэтгэгч Сергей Анатольевич Цыб тус үеэр мэдэгдэв. Хоёр орны Засгийн газрын зүгээс шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлсэн учраас ирэх сарын эхээр болон дундуур 1.3 сая вакциныг хоёр хувааж нийлүүлнэ гэдгээ тэрээр хэллээ. Монголын ард иргэдийг вакцинжуулах ажилд хувь нэмрээ оруулж, цар тахлын амаргүй цаг үеийг хамтдаа даван туулж, хөрш орнуудын найрсаг хамтын ажиллагааны хүрээнд тусалцаа үзүүлж байгаад Шадар сайд талархал илэрхийлээд, цаашид вакцины худалдан авалтыг үргэлжлүүлэх бодлого баримталж байгаагаа дуулгалаа. Түүнчлэн хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд нийгэм, эдийн засгийг сэргээх үр дүнтэй төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байгаагаа Шадар сайд С.Амарсайхан хэллээ.

## НИЙСЛЭЛЭЭС ОРОН НУТАГ РУУ ЗОРЧИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХОРИГЛОЛОО



УОК-ын Х хуралдаан өнгөрсөн баасан гаригт болж, халдварт цар тахлын тархалтын нөхцөл байдал, тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, УОК-ын дэргэдэх эрдэмтэн судлаачдын санал, худалдаа үйлчилгээний байгууллагуудад хийж буй хяналт, шалгалтын дүнгийн талаарх танилцуулга мэдээллийг тус тус сонсож, дараах шийдвэрийг гаргалаа.

Коронавирусийн халдварын тархалт нэмэгдэж, эрсдэл ихсэж буй учир Улаанбаатар хотоос орон нутаг руу зорчих хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 28-ны 6 цагаас эхлэн 14 хоногийн хугацаанд бүрэн хориглолоо. Зөвхөн хүндэтгэн үзэх шалтгаан /эрүүл мэнд, буяны ажил/-тай иргэд, зайлшгүй шаардлагатай ачаа тээвэр /хүнс, шатахуун, өвс, тэжээл, эм эмнэлгийн хэрэгсэл, уул уурхай/-ийн тээвэрлэгчдийг тухайн зорьж буй аймгийн Онцгой комиссын шийдвэр, PCR шинжилгээний хариуг үндэслэн халдвар хамгааллын дэглэмийг хатуу мөрдүүлэн нэвтрүүлэхээр боллоо. Зайлшгүй шалтгаанаар зорчих байгаа тэдгээр иргэдийг тухайн орон нутгийн Онцгой комиссын шийдвэрээр 5-7 хоног тусгаарлахыг аймаг, орон нутгийн Засаг дарга нарт үүрэг болгов.

Мөн Өмнөговь, Дорноговь аймаг руу орох зорчих хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 6 цагаас эхлэн 14 хоногийн хугацаагаар зогсоож, буяны ажил, хүнс, шатахуун, эм, эмнэлгийн хэрэгсэл болон өвс, малын тэжээлийн тээвэрлэлтийг зөвхөн УОК-ын Шуурхай штабаас олгосон зөвшөөрлийг

үндэслэн нэвтрүүлнэ. Энэ хугацаанд буюу 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс тус хоёр аймгийн нутаг дэвсгэрт орших хилийн бүс орчмын сумдын иргэдийг коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтад хамруулах ажлыг эхлүүлэхээр боллоо.

Халдвар илэрсэн Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Завхан, Орхон, Төв, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Увс аймгийг халдварын тархалтын улаан түвшинд 2021 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 6 цагаас 2021 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 6 цаг хүртэлх хугацаанд шилжүүлээ. Харин нийслэлд халдварын тархалтын улбар шар түвшинд шилжсэн хугацааг 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 6 цаг хүртэл сунгах шийдвэр гаргалаа.

Нийслэл болон орон нутагт үүсээд буй халдварын тархалт түүний эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өргөн хүрээнд ариутгал халдваргүйтгэлийг нийтийн эзэмшлийн зам талбайд хийх, улсын онц чухал болон нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий объект, байгууллагад халдвар хамгааллын хатуу дэглэм тогтоож, ногоон бүс үүсгэх байдлаар үйл ажиллагааг явуулахыг үүрэг болголоо. Мөн томоохон зах, худалдааны төв, үйлдвэр үйлчилгээний газрын удирдлага болон төлөөлөгчтэй уулзаж, ажиллах цагийн хуваарьт зохицуулалт хийхийг холбогдох албан тушаалтнуудад даалгалаа.

Эх сурвалж: Засаг.мн



**СОЁМБО СОНИН**  
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАЛДАНБА,  
Д.НАЦАЦДОРЖ

Дарга, ерөнхий редактор  
Хурандаа  
САНЖМЯТАВЫН  
ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сонин редакцал бэлтгэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл бодол сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс 10018  
И-мэйл хаяг:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029